



МОНГОЛ УЛСЫН  
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/224

Улаанбаатар хот

Хөгжмийн зэмсэг, хувцас хэрэглэлийн жагсаалт,  
техникийн тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2024 оны “Морин хуурын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Филармонийн Морин хуур найрал хөгжмийн уран бүтээлчдийн хувцас, хөгжмийн зэмсэг хэрэглэл шинэчлэх багцын жагсаалтыг 1 дүгээр, уран бүтээлчдийн хувцас, хөгжмийн зэмсэг хэрэглэлийн техникийн тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ч.Цэвэгдорж)-д даалгасугай.

САЙД



Ч.НОМИН




Соёлын сайдын 2024 оны 05 дугаар  
сарын 16-ны өдрийн А/224 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

УЛСЫН ФИЛАРМОНИЙН МОРИН ХУУРЫН ЧУУЛГЫН  
ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ, ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ,  
ТОГЛОЛТЫН ИЖ БҮРЭН ХУВЦАСЫГ ШИНЭЧЛЭХ БАГЦЫН ЖАГСААЛТ

Тоног төхөөрөмжийн нэр		Тоо ширхэг	Үнийн дүн /төгрөг/
БАГЦ 1. Дотоодоос авах хөгжмийн зэмсэг		10	60,000,000
1.1	Дотоодоос авах хөгжмийн зэмсэг	10	60,000,000
БАГЦ 2. Хөгжмийн зэмсэг, хөгжмийн зэмсгийн дагалдах хэрэгсэл		201	1,457,000,000
2.1	Хөгжмийн зэмсэг	16	1,228,950,000
2.2	Хөгжмийн зэмсгийн дагалдах хэрэгсэл	47	80,307,200
2.3	Цохивор хөгжим, цохивор хөгжмийн зэмсгийн дагалдах хэрэгсэл	46	112,962,100
2.4	Тоног төхөөрөмж болон дагалдах хэрэгсэл	92	34,780,700
БАГЦ 3. Дотоодын үйлдвэрээс тоглолтын хувцас болон дагалдах хэрэгсэл худалдан авах		212	426,000,000
3.1	Хөгжимчдийн даавуун шар дээл	50	56,000,000
3.2	Хөгжимчдийн цагаан торгон дээл	50	75,000,000
3.3	Хөгжимчдийн цэнхэр торгон дээл	50	150,000,000
3.4	Удирдаачийн дээл	5	13,500,000
3.5	Хөгжимчдийн сонгодог хослол, даашинз	50	111,000,000
3.6	Удирдаачийн сонгодог хослол	2	6,000,000
3.7	Эмэгтэй гоцлол дээл	1	2,500,000
3.8	Эрэгтэй гоцлол дээл	4	12,000,000
<b>Нийт дүн</b>		<b>423</b>	<b>1,943,000,000</b>


Соёлын сайдын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/2024 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАГЦ 1. ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /ДОТООДООС ХУДАЛДАН АВАХ/**




ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ЖАГСААЛТ						
№	Хөгжмийн нэр	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Морин хуур		<p>Царны хийц: технологийн дагуу бэлдэж боловсруулсан өндөр зэрэглэлийн/AAA/ агч /maple/, гацуур мод хосолсон, иш нь мөн ижил хээтэй агч, хар зандан модон тоноглолтой /ишний элэг, хөглөгч чихний бариул, дээд тэвх, татуурга, татуургын дэр/, хөглөгч чих нь уламжлалт дамжуулгатай,</p> <p>Морин хуурт зориулсан винттэй сонгодог загварын модон нумтай, Нумын тросны хөндлөн огтлол нь зөв найман талт, Нумын хялгас нь монгол адууны цагаан өнгөтэй шинээр бэлтгэсэн сүүл байна, /БНХАУ-с ирдэг нум шаардлагад нийцдэггүй тул монгол урлаачийн мастер нум байх/, Дуу баланс, хийцийн статик, кинематик, динамик тэнцлийг бүрэн хангасан байх, Мөн ар өвөр нүүрний /дек даац/, ишний хийц нь хос чавхдасны болон хуруу, нумын даралтын хүчнүүдийн нийлбэрийг бүрэн даах, цар, иш толгойн жингийн тэнцэл тохирсон тогтворжилт сайтай байх,</p> <p>Морин хуурын сайн чанарын даавуун уут.</p>	6	6,000,000	36,000,000
2	Их хуур	 	<p>Царын хийцэд технологийн дагуу бэлтгэж боловсруулсан өндөр зэрэглэлийн евро стандартын /AAA/ агч гацуурын /maple, spruce/ хослол, иш нь мөн долгиолсон хээтэй агч/хээ гэж модлогийн өвөрмөц бүтцийн онцлогийг хэлнэ/, хар зандан модон тоноглолтой /ишний элэг, дээд тэвх, татуурга, татуургын дэр/, гурван чавхдастай, хөглөгч чих нь зориулалтын механик дамжуулгатай концертын зориулалтын их хуур, Хэмжээ нь манай НВ100 загвар 4/4 тэй дүйцнэ,</p> <p><u>Хөгжмийн утас</u>: SPIROCORE австри утас, нэмэлт 1 багц утастай</p> <p><u>Тэвх</u>: Andoig брэндийн өндөр намыг тохируулдаг тэвхтэй дүйцэхүйц байх, <u>Мастер нумтай</u>, Нумын хялгас нь монгол адууны шинээр бэлтгэсэн цагаан өнгөтэй байх, Хөгжмийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд орчны температур, чийглэгийг онцгой анхаарч байх хэрэгтэй,</p>	4	6,000,000	24,000,000


			тохиромжтой, Мөн нарны шууд тусгал, халаагч төхөөрөмжийн ойр удаан тавих, байрлуулахгүй байх, хүйтэн орчноос дулаан газарт огцом гаргаж чавхдасанд хүчдэл өгч хөглөх зэрэг нь хөгжмийг эвдрэлд хүргэдгийг анхаарах хэрэгтэй.			
<b>ДҮН</b>				<b>10</b>	<b>60,000,000</b>	

**БАГЦ 2. ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ  
/ ГАДААДААС ХУДАЛДАН АВАХ/**

ГАДААДААС АВАХ ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ЖАГСААЛТ						
№	Хөгжмийн нэр	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Дунд хуур (виолончель)		<p>Европын гар хийцийн хагас мастер хөгжимтэй дүйцэхүйц, хөгжмийн ар, хажуу болон иш нь сайн чанарын AAA-с дээш зэрэглэлийн европ агч /maple/ мод байна, 4/4 хэмжээтэй, Нүүр нь сайн чанарын буюу AAA-с дээш зэрэглэлийн европ гацуур мод байна, Чих, хурууны давцан, татлага мод тус бүр сайн чанарын хар модоор (Ebony), тэвхийг сайн чанарын агч модоор хийсэн байх,</p> <p><u>Нум:</u> 4/4 хэмжээтэй Pernambuco модоор хийгдсэн сайн чанарын модон эсвэл карбон байх, Хялгасыг монгол адуун шинэ цагаан хялгасаар хялгасласан байх, Хөглөгч нь чихэндээ механик дамжуулгатай,</p> <p><u>Хөгжмийн утас:</u> Larsen, SPIROCORE Thomastik утастай байх, /Зураг/ <u>Маар/Тэвх/:</u> Aubert VB-14 Old European дүйцэхүйц</p> <p><u>Хөнгөн, сайн чанарын хатуу хайрцагтай /футляр/</u> Аль ч улиралд зохицохуйц Солонгос улсын хөгжмийн уут, Хөгжмийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд орчны температур, чийглэгийг онцгой анхаарч байх хэрэгтэй, Эдгээр орчны харьцангуй чийглэг нь W=25-40%, температур нь 0-25C байх нь тохиромжтой, Мөн нарны шууд тусгал, халаагч төхөөрөмжийн ойр удаан тавих, байрлуулахгүй байх, хүйтэн орчноос дулаан газарт огцом гаргаж чавхдасанд хүчдэл өгч хөглөх зэрэг нь хөгжмийг эвдрэлд хүргэдгийг анхаарах хэрэгтэй.</p>	4	70,000,000	280,000,000
2	Ёочин		<p>Мэргэжлийн, концертын ёочин хөгжим <u>Загвар:</u> 402. Дуу хаагч педальтай загвар (Muting pedal). Энэ загварын их бие нь Африкийн ягаан зандан мод (African violet sandalwood) мөн Мьянмарын улаан (Myanmar rosewood) модоор хийгдсэн байна. "YUEHAI", "CHENGYUE" зэрэг улсын үйлдвэрийн брэндтэй дүйцэхүйц байх. /хөгжмийн их биед үйлдвэрийн</p>	2	20,000,000	40,000,000

		 	<p>тамга байх/ Царын буюу резонансын хэсэг нь зориулалтын эртнээс ашиглаж ирсэн тоорой буюу Хятадаар Тун-Му модоор хийгдсэн /Paulownia/, хөглөгч чихний суух хэсэгт нягтрал өндөртэй навчит үүлдрийн модыг ашиглаж хөг барих байдлыг хангаж өгсөн байдаг. Энэхүү 402 загварын Ёочин хөгжмийн зэмсэг нь нэмэлтээр цуурай дарагч буюу педаль (Muting pedal) суурилуулсан загвар байх ба бусад 402 загвараас үүгээрээ онцлог ялгаатай байдаг.</p> <p>Нийт жин: b=10/11, /30кг/</p> <p>Зэмсгийн үндсэн хэмжээс: /см/ L=117/79, B=51</p> <p><u>Акустик үзүүлэлт:</u> Чавхдасны тоо: N=145, Мар-55ш 4-Эгнээ, Тэвх-8ш, Пошк-66ш Аялгууны багтаамж: Их октавын Фа /F/-с 4-р октавын До /4с/ Зөөлөвчтэй хулсан хос цохиур /4 хос/ - мастер хийцтэй (tulip design) хайрцгийн хамт Запаасаар-цохиурын резин 20 ширхэг, пошик /метал цилиндр өнхрүүш/ 20 ширхэг Дугуйтай сайн чанарын хийцтэй хөл, хамгаалалтын хатуу хайрцагтай (Hard case) тус бүр 2 ширхэг. Хөгжмийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд орчны температур, чийглэгийг онцгой анхаарч байх хэрэгтэй. Эдгээр орчны харьцангуй чийглэг нь W=25-40%, температур нь 0-25°C байх нь тохиромжтой. Мөн нарны шууд тусгал, халаагч төхөөрөмжийн ойр удаан тавих, байрлуулахгүй байх, хүйтэн орчноос дулаан газарт огцом гаргаж чавхдасанд хүчдэл өгч хөглөх зэрэг нь хөгжмийг эвдрэлд хүргэдгийг анхаарах хэрэгтэй.</p>			
3	Ятга (164см)		<p>Мэргэжлийн, концертын ятга. Энэ зэрэглэлийн зэмсгийн их бие нь Мьянмарын улаан модон /Myanmar Rosewood/ хийцтэй, царын буюу резонансын хэсэг нь зориулалтын эртнээс ашиглаж ирсэн тоорой буюу Хятадаар Тун му /Paulownia/, харин хөглөгч чихний суух хэсэгт нягт өндөртэй навчит үүлдрийн модыг ашигласан байх. Тэвх нь хөгжмийн зэмсгийн хийц урлалын зарчмын дагуу их биеийн үндсэн материалаар /Paulownia/ хийгдсэн эсхүл хар модон 21 ширхэг байх. Тэвхэнд утас тохогдох хэсэгт зориулалтын хатуу ясан материал суулгасан байх. Энэ нь чавхдас шигдэж орохоос хамгаалагдсан байх. Зэмсгийн хүрээ нь улаан модны үндсэн өнгөтэй, харин царын хэсэг нь бор цайвар өнгөтэй, их биеийн нүүр буюу урагш харсан хэсэг нь гоёлын чимэглэл сийлбэр, хээ, зураг, ханз бичиг байхгүй цулгүй байх./дотор хэсэгт байж болох/ Чавхдасны сүвний бүх</p>	6	19,500,000	117,000,000

			<p>хэсэг бүхий дээд, доод 42 амсар нь метал гуурсан хамгаалалттай байх. / Хятадын №1 үндэсний үйлдвэр болох Шанхай хотын “Дунхуан” /Dunhuang/ үйлдвэрийн мэргэжлийн концертын ятга хөгжимтэй чанарын хувьд дүйцэхүйц байх./Зэмсгийн үндсэн хэмжээс: /см/ L=163, B=34, b=7</p> <p>Акустик үзүүлэлт: Чанга тод дуугаралттай, чичиргээ/вибраци/ сайн авдаг, хөг сайн барьдаг байх. багтаамж: Их октавын Re /D/, 3-р октавын Re/D/ Чавхдасны материал: Нийлэг бүрээстэй метал голтой, мэргэжлийн өндөр шаардлага хангасан чанартай байх. Дагалдах иж бүрдэл: Ятгын электрон камертон, хөглөгч түлхүүр,1ком хумс, Тавиур хөл, Ятга хөгжмийн уут /чехол/ Тээвэрлэлтэд анхаарах зүйлс: Хөгжмийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтэд орчны температур, чийглэгийг онцгой анхаарч байх.</p>			
4	Ятга жижиг 135см		<p>Их бие нь хар модон хийцтэй, хөглөгч чихний суух хэсэгт нягт өндөртэй навчит үүлдрийн модыг ашигласан байх. Тэвх нь хар модон 21 ширхэг байх. Тэвхэнд утас тохогдох хэсэгт зориулалтын хатуу ясан материал суулгасан байх. Энэ нь чавхдас шигдэж орохоос хамгаалагдсан байх. Зэмсгийн царын хэсэг нь бор цайвар өнгөтэй, их биеийн нүүр буюу урагш харсан хэсэг нь гоёлын чимэглэл сийлбэр, хээ, зураг, ханз бичиг байхгүй цулгуй байх. Толгойн хэсэгт цахилгаан оролттой байх ба дагалдах кабель,батарей дагалдсан байх.</p> <p>Зэмсгийн үндсэн хэмжээс: (см) L=135, B=35,b=7</p> <p>Акустик үзүүлэлт: Чанга тод дуугаралттай, чичиргээ (вибраци) сайн авдаг, хөг сайн барьдаг байх. Багтаамж: Их октавын Re /D/, 3-р октавын Re/D/</p>	1	4,550,000	4,550,000
5	Пикколо Флейт		<p>Yamaha YPC-87R брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц</p> <p>Их бие нь Select-Grenadilla мод, толгойн бөгж болон товчлуур хэсгүүд цэвэр мөнгөөр хийсэн байх(Sterling silver), Split E механизмтай. Сүмбэ, алчуур, тос, уут (чехол) дагалдсан байх.</p>	1	28,600,000	28,600,000
6	Флейт		<p>(Sterling silver), эсхүл (solid silver). A.G.F.E.D даралтууд нүхтэй, Доод өнгө бага октавын Си нот гардаг байх. Сүмбэ, алчуур, нүхний бөглөө, тос, уут (чехол) дагалдсан байх. Эсхүл Muramatsu Flute-SR Miyazawa headjoint #UMIYF231-14k model түүнтэй дүйцэхүйц</p>	1	58,800,000	58,800,000


7	Төгөлдөр хуур		Cabinet;Color-Polished Ebony Finish-Polished (Matte lid top & Prop) Size/Weidth Dimensions Width 160cm (63") Height 103cm (40 1/2") Depth 275cm (9") Weight 491kg (1069lbs) Control interface Keyboard Number of keys 88 Key Surfaces-White Ivorite Key Surfaces-Black Ebony Pedal type Sostenuto Lid Prop positions 3 Prop safety stop yes Edge Beveled Key cover Lid/Fallboard Locks yes Soft-close Fallboard Yamaha CFX grand piano той дүйцэхүйц	1	700,000,000	700,000,000
<b>ДҮН</b>				<b>16</b>	<b>1,228,950,000</b>	

**ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ, ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ,  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**



<b>ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ</b>						
№	Хөгжмийн дагалдах хэрэгсэл	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>ИХ ХУУР ХӨГЖМИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ</b>						
1	Их хуур хөгжмийн утас		SPIROCORE австри утас, hand made эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	4	900,000	3,600,000
2	Их хуур хөгжмийн нум		Их хуур хөгжмийн нум нь Fiddlerman Hybrid French Style Doudle bass bow брэндийн нум эсхүл түүнтэй дүйцэхүйц мастер нум байх	4	1,035,000	4,140,000
3	Их хуур хөгжмийн хатуу хайрцаг		Контрабасс хөгжмийн 3/4 хэмжээтэй хатуу хайрцаг (футляр) Хятадын Aileen or OEM брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх.	4	6,054,750	24,219,000











4	Их хуур хөгжмийн зөөлөн уут		Контрабасс хөгжмийн $\frac{3}{4}$ хэмжээтэй зөөлөн уут	4	983.550	3.934.200
<b>ЁОЧИН ХӨГЖМИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ</b>						
5	Ёочин хөгжмийн хөлийн хатуу хайрцаг		Дугуйтай сайн чанарын хийцтэй хөл, хамгаалалтын хатуу хайрцаг (Hard case)	2	526,500	1,053,000
6	Ёочин хөгжмийн хөглөгч (camerton)		KORG ot-120 Orchestral Tuner	2	200,000	400,000
7	Ёочин хөгжмийн утас	 <small>402 YANGQIN STRINGS, #15 - #30, SELECTABLE -- 402# 揚琴琴弦</small>	Ком утас (strings #15-#30) Модель 402	2	576,000	1,152,000
<b>ЯТГА ХӨГЖМИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ</b>						
8	Ятга хөгжмийн утас		Дунхуан үйлдвэрийн Б чавхдастай дүйцэхүйц байх, Чавхдасны материал: Германы Рослау гангаар хийгдсэн бөгөөд тод, хүчтэй өнгөтэй , утсыг чангалахад чанартай байх (1 ком дотроо 21 ширхэг байдаг)	12	350,000	4,200,000
9	164см том Ятга хөгжмийн хайрцаг /футляр/		Футлярны материал: Хатуу нягт хөөсөнцөр дотортой, ус нэвтэрдэггүй чийгт тэсвэртэй даавуун гадаргуутай, тээвэрлэлтэд тэсвэртэй резин дугуйтай байх, хар,саарал өнгөтэй хөнгөн , 4кг-аас дээшгүй жинтэй байх, Хэмжээ: дотор хэсэг:/см/163*35*30 гадна хэсэг: 176*42*32	6	650,000	3,900,000
10	133-145см Ятга хөгжмийн хайрцаг /футляр/		Футлярны материал: Гаднах материал хатуу байх, хатуу нягт дотортой, ус нэвтэрдэггүй чийгт тэсвэртэй, тээвэрлэлтэд тэсвэртэй резин дугуйтай байх, хар,саарал өнгөтэй хөнгөн , Хэмжээ: /см/ урт 145 см, дээд талын өргөн 30см, доод талын өргөн 30см,	6	364,000	2,184,000
<b>ФЛЕЙТ ХӨГЖМИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ</b>						



11	Флейт хөгжмийн толгой		Флейт хөгжмийн толгой хэсэг /Cresta cut/ Miyazawa Headjoint UMIYF231-14K-тай байх, эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	31,525,000	31,525,000
<b>ДҮН</b>				49	<b>80,307,200</b>	

**ЦОХИВОР ХӨГЖИМ, ЦОХИВОР ХӨГЖИМ ИЙН ЗЭМСГИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН  
ЖАГСААЛТ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Хөгжмийн дагалдах хэрэгсэл	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Маримба болон вибратоны Сэт цохиур		Маримба болон вибратоны Сэт цохиурууд/хатуу, зөөлөн, дундын/ Keiko Abe брэндийн цохиур эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх.	1	1,105,000	1,105,000
2.	Цангийн цүнх		Цангийн цүнх 18-22 инчийн цан багтааар жийргэвчтэй гаднаа халаастай үүрдэг мөрөвчтэй байх Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	398,000	398,000
3.	Жижиг бөмбөрийн хатуулгатай цүнх үүрдэг		Жижиг бөмбөрийн хатуулгатай цүнх үүрдэг Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	398,000	398,000
4.	Цан		18, 20 инчийн концертын зориулалттай 2 ширхэг цан /Zildjian/ брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	2	1,560,000	3,120,000
5.	Тимпани сэт цохиур		Тимпани хөгжмийн хулсан иштэй сэт цохиурууд/хатуу, зөөлөн, дундын/ Vic Firth брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	530,000	530,000
6.	Тимпаны цохиуруудад зориулсан цүнх		Тимпаны цохиуруудад зориулсан цүнх. байх Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	177,000	177,000
7.	Хөгтэй хөгжимд зориулсан цүнх		Хөгтэй хөгжмийн цохиуруудад зориулсан цүнх. байх Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	310,000	310,000




8.	Жижиг бөмбөрийн хөл		Жижиг бөмбөрийн хөл өндөр болдог. /ком бөмбөрийнх биш/ Pearle брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай, чангалдаг боолтууд нь төмөр байх; хэрэглээг хангана 100мл байх;	2	265,000	530,000
9.	Цангийн хөл		Цангийн хөл өндөр болдог. /ком бөмбөрийнх биш/ Pearle брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай, чангалдаг боолтууд нь төмөр байх	2	380,000	760,000
10.	Жижиг бөмбөрийн цохиур		Жижиг бөмбөрийн цохиур 2 хос. 2 талдаа модон болон зөөлөн эсгий толгойтой байх. Vic Firth брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	2	155,000	310,000
11.	Шэкер		Шэкер хар өнгөтэй пластик материалтай дунд хэмжээтэй Luic Conte эсхүл Meinl брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	1	66,000	66,000
12.	Том хонх/campane/ хөгжмийн цохиур,		Том хонх/campane/ хөгжмийн 1 хос цохиур, модон иштэй резин толгойтой байх. Shopro брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	125,000	125,000
13.	Дуут мод		Өндөр болдог суурьтай 5н хөгтэй дуут мод, пластик материалтай, хөлийн чангалдаг боолтууд төмөр байх. Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	1,238,000	1,238,000
14.	Жижиг хонх /campanelli/ хөгжмийн цохиур		Жижиг хонх/campanelli/ хөгжмийн 1 хос цохиур. төмөр толгойтой байх. Yamaha брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	177,000	177,000
15.	Жижиг хонх /campanelli/ хөгжмийн цохиур		Жижиг хонх/campanelli/ хөгжмийн 1 хос цохиур. пластик толгойтой байх Yamaha брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	163,000	163,000
16.	Царгил хөгжмийн (silafone цохиур)		Царгил хөгжмийн/silafone/ 1 хос цохиур. Пластик толгойтой Yamaha брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	1	177,000	177,000
17.	Хулсан шотка		Хулсан шотка, LP брэндтэй дүйцэхүйц байх	1	110,000	110,000


18	Вибрафон		Вибрафон 4 октав.суурь нь өндөр нам болох тохиргоотой байх.Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	1	43,953,000	43,953,000
19	silafone		silafone 4 октавтай,хөг нь модон биш пластик материалтай,суурь нь өндөр нам болгох тохиргоотой. Адамс брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	1	16,415,000	16,415,000
20	кампанел		кампанел 3-3.5 октавтай, педальтай бат бөх суурьтай байх.Уамаһа брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	15,600,000	15,600,000
21	Харанга		Харанга хөлтэй,цохиуртай. reast брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх.	1	1,149,200	1,149,200
22	Тимпани цохиур		тимпани цохиур(дунд) Kato брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	522,600	522,600
23	Тимпани цохиур		тимпани цохиур(чанга) Kato брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	522,600	522,600
24	Тимпани цохиур		тимпани цохиур(Соло) Kato брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	522,600	522,600
25	Тимпани цохиур		тимпани цохиур(Соло) Kato брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	522,600	522,600
26	Электро бөмбөр (pedal)		Электро бөмбөр (pedal) Roland брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	1,046,500	1,046,500
27	Электро бөмбөр (control)		Электро бөмбөр (control) Roland брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	910,000	910,000
28	Электро бөмбөр (хөл)		Электро бөмбөр (хөл) Roland брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	886,600	886,600
29	Электро бөмбөр (дэлгэц)		Электро бөмбөр (дэлгэц) Roland брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	3,958,500	3,958,500

30	Хонх		Хонх 36 хонхтой Yamaha брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	400,400	400,400
31	Шэкер		Студио шэкер синтетик биетэй байх, Meinl percussion брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	110,500	110,500
32	Давхар шигшрэг		Давхар шигшрэг Meinl percussion брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	1	273,000	273,000
33	Бороо Rainstick Rainmaker shaker-XL -32 inch		Rainstick Rainmaker shaker-XL -32 inch	1	145,600	145,600
34	Тимпани хальс		Premier England эсвэл Yamaha Тимпаний хальс эсхүл түүнтэй дүйцэхүйц байх Code 002221-23'inch 002801-26'inch 009696-29'inch 001746-32'inch	4	617,500	2,470,000
35	Кастанет		Кастанет чангалагч боолт нь төмөр байх. VicFirth брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	1	309,400	309,400
36	Том бөмбөр		Том бөмбөр бат бэх өндөр нам, урагш хойш болох тохиргоотой, Adams брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх. 29' байх	1	11,570,000	11,570,000
37	Фруста		Фруста Asiatic hardwood 18" инч байх	1	290,000	290,000
38	Цохиуруудын тавиур		Хөл нь өндөр нам болдог, төмөр материалтай. Зөөлөвч сайтай чанартай байх. Pearl брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц чанартай байх	2	845,000	1,690,000
<b>ДҮН</b>				<b>46</b>	<b>112,962,100</b>	

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛҮҮДИЙН, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Хөгжмийн дагалдах хэрэгсэл	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
---	----------------------------	-------	------------------------	-----	----------	----------

1.	Утсан хөгжим үлээвэр хөгжмийн микрофон DPA		<p>Microphone Type: Pre-polarized Condenser Polar Pattern: Supercardioid Diaphragm Size: Small Frequency Range: 20Hz-20kHz Max SPL: 142 dB SPL Signal to Noise Ratio: 71 dB (A weighted) Self Noise: 23 dB (A weighted) Output Impedance: 30-40 ohms Color:Black Connector: MicroDot Cable Length:5,9 ft, Weight:0,95 oz, Included Accessories: Clip for Violin Manufacturer Part Number:4099-DC-1-199-V DPA instrument mic 4099 Дагалдах хавчааруудын жагсаалт</p> <p>DPA CM4099 instrument mic clip 8 ширхэг Cello mic clip 2 ширхэг Microphone clip bass 2 ширхэг Ятга Clip 5 ширхэг Үлээвэр clampount 5ш</p>	6	2,240,000	13,440,000
2.	Тоглолтын хувцасны цүнх		<p>Тоглолтын иж бүрэн хувцас багтах хэмжээтэй, цахилгаан чанартай, усны хамгаалалттай материалтай байх. Үүргэвч нь гар бариултай, мөрөвчтэй, крослож үүрч болохоор байх.</p>	50	200,000	10,000,000
3.	Удирдаачийн нотны тавиур		<p>Ноотны тавиур: цул модоор хийсэн, суурь нь таван хөлтэй, босоо хоолой 25 мм, үндсэн өндөр 63 см хөгжмийн тавиурын өндөр:80 см гуурстай оруулгатай 97-140 см Тавцангийн Т хэлбэрийн өргөтгөл 4200Т Хөгжмийн тавиурын өргөтгөлийн хоолой 4142, Колберг/KOLBERG/ брэндийн 4511HSW тавиур эсхүл түүнтэй дүйцэхүйц байх. Доод тавцан нь хатуу модон (58 мм-ийн гүн) таван нэмэлт бэхлэгдсэнтэй тусгай боолтоор бэхлэгдсэн бөгөөд нэмэлт боолтоор бэхлэгддэг. Суурь нь өндөр чанарын гангаар хийгдсэн.</p>	1	4,340,700	4,340,700

			Ширээний холбогч нь зургаан эрэг бүхий тусгайлан зохион бүтээсэн холбох хэрэгсэлтэй бөгөөд, ширээг тохируулах боломжийг олгодог байх. 105' өнцөгтэй, эрэг шураг нь найдвартай чангалах боломжийг олгодог байх, ширээ нь хар өнгөөр өнгөлгөөтэй. Бусад нь лак эсвэл биологийн аргаар боловсруулсан гадаргуутай.			
4.	Нотны тавиур		Жин 1,28 кг Өндөр 530-1200 мм Даац 2,5 кг Хураагдсан хэмжээ 88 x 55x 470 мм Тавиурын хэмжээ: 410x235 мм Материал: хөнгөн цагаан, төмөр Hercules брэнд эсхүл түүнтэй дүйцэхүйц байх	35	200,000	7,000,000
<b>ДҮН</b>				<b>93</b>	<b>34,780,700</b>	

### БАГЦ 3. ТОГЛОЛТЫН ИЖ БҮРЭН ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Хувцасны нэр	Зураг	Техникийн тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цагаан торгон дээл (эрэгтэй)		Малгай нь өндөр оройтой, хамба хилэн хүрээтэй, цагаан залаатай, цагаан хоргой эмжээртэй Дээл нь цагаан торго, нимгэн дотортой, цэнхэр торгон нударгатай, өргөн цагаан хоргой эмжээртэй, нарийн хошмогтой, товч шилбэтэй Бүс нь цэнхэр өнгийн даалинтай, цагаан зөөлөн арьсан ээтэн хоншоортой гутал	30	1,500,000	45,000,000
2	Цагаан торгон дээл (эмэгтэй)		Малгай нь өндөр оройтой, цагаан хилэн хүрээтэй, цагаан залаатай, нарийн цагаан хоргой эмжээртэй Дээл нь залгаа хатан мөртэй, ханцуй зөөлөн суналттай материалтай нь нударгатай, товч шилбэтэй, дэрвэгэр хормойтой, өргөн цагаан хоргой эмжээртэй, нарийн хошмогтой. Бүс нь цагаан хоргойгоор хийгдсэн, Бүсний 2 талдаа торгон хавтагатай, хоргой эмжээртэй, мөнгө, сувдан ээмэг, унжуургатай.	20	1,500,000	30,000,000

3	Шар дээл (эрэгтэй)		Малгай нь бөөрөнхий оройтой, хар хамба хүрээтэй, улаан залаатай, шар хоргой малгай Дээл нь цэвэр даавуун материалтай, хар хилэн эмжээртэй, туузаар даруулсан, доторгүй, шар хоргой додигтой. Бүс нь хар хамба, хар нарийн туузан эмжээртэй, цагаан зөөлөн арьсан ээтэн хоншоортой гутал	30	1,200,000	36,000,000
4	Шар дээл (эмэгтэй)		Малгай нь бөөрөнхий оройтой, хилэн хүрээтэй, улаан залаатай, шар хоргой малгай Дээл нь цээж хормой тусдаа, шар дурдан дэрвэгэр хормойтой, цээж нь хамба хилэн материалтай шар хоргой эмжээртэй, мөнгө,сүвдан ээмэг унжуургатай.	20	1,000,000	20,000,000
5	Цэнхэр торгон дээл (эрэгтэй) Загварт бага зэргийн өөрчлөлт орж болно		Дээлийн бүрдэлд: дээл нь нимгэн дотортой, хөх цэнхэр өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр, зах болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу, ширээстэй, агсраг хэрэгсэлтэй бүс, торго болон хамбан, мөнгөн чимэглэлтэй малгай, арьсан гоёлын хээтэй гутал	30	3,000,000	90,000,000
6	Цэнхэр торгон дээл (эмэгтэй) Загварт бага зэргийн өөрчлөлт орж болно		Дээлийн бүрдэлд: дээл нь дотортой, хөх цэнхэр өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр, зах болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу, хөөмөл арьсан бүс хэрэгсэлтэй, торго болон хамбан, мөнгөн чимэглэлтэй малгай, арьсан гоёлын хээтэй гутал, толгойн гоёл болон ээмэг мөнгөн болон чулуун материалтай, арьсан гоёлын хээтэй гутал	20	3,000,000	60,000,000
7	Сонгодог хослол (эрэгтэй)		Бүрдэлд: сайн чанарын смокинг, бүс, цагаан цамц, бантик, алчуур, товч Boggi Milano той дүйцэхүйц, арьсан лакан гутал,	30	2,700,000	81,000,000
8	Сонгодог даашинз (эмэгтэй)		Бүрдэлд: цамц, хормой, лакан түфль, ээмэг зүүлт	20	1,500,000	30,000,000
9	Удирдаач Т-1 – цагаан дээл	Загварыг шинээр гаргана	Дээлийн бүрдэлд: эр, дээл хатгамалтай, арьсан, хөөмөл тольтой бүс, малгай, гутал, жижиг хэрэгсэл	1	2,700,000	2,700,000

10	Удирдаач хар дээл Т-2-х	Загварыг шинээр гаргана	Дээлийн бүрдэлд: эр, дээл хатгамалтай, арьсан, хөөмөл тольтой бүс, малгай, гутал	1	2,700,000	2,700,000
11	Удирдаачийн цэнхэр дээл Т-3-		Дээлийн бүрдэлд: хар хөх өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу хатгамалтай бүс, захтай, арьсан гоёлын гутал	1	2,700,000	2,700,000
12	Удирдаачийн сонгодог хослол-Т		Бүрдэлд: сонгодог фрак, өмд, бүс, цагаан цамц, бантик ,алчуур, товч Boggi Milano той дүйцэхүйц, арьсан лакан гутал	1	3,000,000	3,000,000
13	Удирдаачийн цагаан дээл Ж-1-	Загварыг шинээр гаргана	Дээлийн бүрдэлд: эр, дээл хатгамалтай, арьсан, хөөмөл тольтой бүс, малгай, гутал	1	2,700,000	2,700,000
14	Удирдаачийн хар дээл Ж-1-		Дээлийн бүрдэлд: эр, дээл хатгамалтай, арьсан, хөөмөл тольтой бүс, малгай, арьсан гоёлын хээтэй гутал	1	2,700,000	2,700,000
15	Удирдаачийн сонгодог хослол -Ж		Бүрдэлд: сонгодог фрак, өмд, бүс, цагаан цамц, бантик, товч Boggi Milano той дүйцэхүйц, арьсан лакан гутал	1	3,000,000	3,000,000
16	Гоцлол хөгжимчин дээл (эмэгтэй)		Дээлийн бүрдэлд: ягаан өнгөтэй наран хормойтой торгон болон габирдин хормойтой дээл, корсеттай хатгамлаар чимэглэсэн, арьсан бүс, толгойн гоёл болон малгай, ээмэг, унжуургатай.	1	2,500,000	2,500,000
17	Гоцлол хөгжимчин дээл (эрэгтэй)		Дээлийн бүрдэлд: улбар шар өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр болон хормой дээрээ алтан шар утсан хатгамалтай, эмжээр сайн чанарын пүүсүү бүс, захтай, бэлгэдэл бүхий товчтой, торго хамбан малгай, арьсан гоёлын хээтэй гутал	1	3,000,000	3,000,000



18	Гоцлол дээл хөөмэй (эрэгтэй)		Дээлийн бүрдэлд: цагаан өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу хатгамалтай бүс, захтай, торго болон хамбан иж бүрэн малгай, арьсан гоёлын хээтэй гутал	1	3,000,000	3,000,000
19	Гоцлол дээл уртын дуучин (эрэгтэй)		Дээлийн бүрдэлд: номин ногоон өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу хатгамалтай бүс, захтай, торго болон хамбан малгай, арьсан гоёлын хээтэй гутал	1	3,000,000	3,000,000
20	Гоцлол дээл хөөмэй (эрэгтэй)		Дээлийн бүрдэлд: хар хөх өнгөтэй, сайн чанарын 100 % хүр хорхойн шүлсээр нэхсэн торго, мөр болон хормой дээрээ хатгамалтай, эмжээр өнгө дагуу хатгамалтай бүс, захтай, торгон болон хамбан оройтой малгай, арьсан гоёлын гутал	1	3,000,000	3,000,000
<b>ДҮН</b>				<b>212</b>		<b>426,000,000</b>